# ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 2 дугаар сарын 27 -ны өдөр Мандалговь хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үзүүлэлтийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

## ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үзүүлэлтийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан арга зүйгээр Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу unelgee.gov.mn –ийн “Ил тод байдлын шалгуур үзүүлэлт” цэсэд байршсан 46 шалгуур үзүүлэлтэд үндэслэн хийв.

## ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН:

Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 46 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 12 сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3 -т заасан аргачлалын дагуу хяналт- шинжилгээ, үнэлгээг хийхэд 100 хувьтай байна. Нийт 46 шалгуур үзүүлэлтээс 3 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт аймгаас гарах боломжгүй буюу хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна.

Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

| № | Үзүүлэлт | Заалтын тоо | 100 | 70 | ХТХБ | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 10 | 10 | | | 100 |
| 2 | Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 6 | 6 | | | 100 |
| 3 | Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 15 | 15 | | | 100 |
| 4 | Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 2 | 2 | | | 100 |
| 5 | Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 13 | 11 | | 2 | 100 |
| 6 | Дүн | 46 | 46 | | | 100 |

Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу аймгийн сайтад мэдээлэл байрлуулах арга зүйн сургалтыг 15 сум, 23 агентлагийн мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүдэд 2 удаа зохион байгуулж, аймгийн сайтын сум гэсэн цэсэд сум бүрд 46 шалгуур үзүүлэлтээр цэс үүсгэн мэдээллийг байршуулах нөхцөл боломжоор хангасан.

Шил ажиллагааны хүрээнд аймгийн сайтад шинэчлэл хийж 46 шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг бүрэн байршууллаа.




Мөн аймгийн албан ёсны вейб сайтад 46 шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээлэл оруулах цэс үүсгэн холбогдох албан тушаалтнуудад хариуцуулснаар

мэдээллийг хугацаандаа оруулж үзүүлэлтийн хувь урд оноос ахисан үзүүлэлттэй байна.

Дундговь аймгийн албан ёсны www.dundgovi.gov.mn сайтын Цаг үеийн мэдээ цэсэд 187, Видео мэдээ цэсэд 16, Зар мэдээлэл цэсэд 77, 15 сумын 322, 24 төрийн байгууллагын 325, нийт 927 мэдээллийг аймгийн сайтад байршуулж олон нийтэд хүргэсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газрын пэйж хуудсанд 2714 мэдээ, цахим хуудсаар нийт 3641 мэдээ байршуулсан нь өмнөх оны мөн үеэс 712-аар өссөн үзүүлэлттэй байна. Мөн тайлант хугацаанд пэйжийн дагагч–28900 болж өмнөх оноос 16,2 хувь өсөж мэдээллийн хүртээмж нэмэгдсэн үзүүлэлттэй байна.






Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 23 агентлаг, 15 сум өөрийн цахим хуудсандаа байгууллагын бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, харилцах утасны дугаар,хаяг байршил зэрэг мэдээллийг байршуулж иргэд мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн байна.







Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс захиргааны байгууллагын үйл ажиллагаа болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн 622 тайлан зөвлөмжийг байршуулсан байна.


ДУНДГОВЬ АЙМАГ
АЛБАН ЁСНЫ ЦАХИМ ХУУДАС
Хайх . . .
УТАСНЫ ЖАРГААЛТ
САНАЛ, ХҮСЭЛТ ИЛГЭЭХ
ӨМНӨХ ХУВИЛБАР
НҮҮР ХУУДАС
АЙМГИЙН ТУХАЙ
НУТГИЙН УДИРДЛАГА
БАРИМТ БИЧИГ
МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ
ШИЛЭН ТӨСӨВ
ИЛ ТОД БАЙДАЛ
ТАСЗӨВЛӨЛ
СУМД
ИЛ ТОД БАЙДАЛ
НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛ
ҮЙЛ АЖИЛЛАГАА
Стратеги, зорилго, зорилтын хэрэгжилт
Албан хаагчдын цахим хаяг, утасны жагсаалт
Үйл ажиллагааны болон Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмж
Батлагдсан албан тушаалын тодорхойлолт, чиг үүрэг
Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ
ХҮНИЙ НӨӨЦ
ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
2024-02-15
ДУНДГОВЬ АЙМАГТ 2023 ОНД ХЭРЭГЖСЭН ХУУЛЬ ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
2024-02-01
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
2024-02-01
ДУНДГОВЬ АЙМГИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН
2024-02-01
ТАЙЛАН


ОНЦЛОХ МЭДЭЭ
2024 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
2.000.000₮
2024-02-05
ТЭРГҮҮНИЙ СУМ, БАЙГУУЛЛАГУУДАД ШАГНАЛ ГАРДУУЛЛАА
ДУНДГОВЬ АЙМГААС "УЛСЫН ХОШОЙ АВАРГА МАЛЧИН" НЭГ, "УЛСЫН АВАРГА МАЛЧИН" 10 ТОДОРЧЭЭ
2024-02-07
ОТРЫН ЯВУУЛЫН ШТАБ АЖИЛЛАВ
2024-02-02
АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИСС ХУРАЛДЛАА
2024-01-27
ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ
2024-02-05
АХМАДАД ЭЭЛТЭЙ БАЙГУУЛЛАГА, БАГИЙН ШАГНАЛЫГ ГАРДУУЛАВ
2024-02-01
НЭГДСЭН ЭМНЭЛЭГТ КОМПЬЮТЕР ТОМОГРАФЫН ШИНЖИЛГЭЭГ ТОГТМОЛ ХИЙЖ ЭХЭЛЛЭЭ
2024-01-31
"ТА ТАТГАЛЗ - БИД ДЭМЖЬЕ" СЭДЭВТ НӨЛӨӨЛЛИЙН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА
2024-01-29
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ БАЙНА

Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоол шийдвэрийг нээлттэй ил тод байлгах зорилгоор www.dundgovi.gov.mn аймгийн нэгдсэн сайтын “Эрх зүйн акт” цэсийг Legalinfo  эрх зүйн мэдээллийн нэгдсэн системтэй холбон хайлт хийх боломжийг бүрдүүлсэн.

Мөн үйл ажиллагаандаа мөрдөх хууль, дүрэм, журмын жагсаалт, Аймгийн Засаг даргын 352 захирамж, ЗДТГ-ын даргын 233 тушаалыг эрх зүйн акт цэсэд оруулсан.







Ажлын байрны сул орон тооны зар албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам, албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм,  хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам,  хүний нөөцийн удирдлагын ил тод



байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам зэргийг сайтад журмын дагуу байршуулсан.




2024 оны төсвийн төсөл болон 2023 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт,санхүүгийн хагас бүтэн жилийн тайлан зэргийг Ил тод байдал цэсийн төсөв санхүү хэсэгт байршуулсан нээлттэй мэдээлсэн.



## ИРГЭДЭЭС ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТУХАЙ

2023 оны жилийн эцсийн байдлаар Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар болон 15 сум, 23 агентлагт хандаж иргэдээс биеэр, цахимаар, утсаар, бичгээр, нийт 3162 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 3141 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж 100 хувийн гүйцэтгэлтэй. Хугацаа хоцорч шийдвэрлэсэн өргөдөл байхгүй байна.




Аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт хандан 130 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснээс 100 хувь шийдвэрлэж мөн 11-11 төвөөс 53 өргөдөл гомдол, санал хүсэлт ирүүлснээс 6 өргөдлийг 30 хоног сунган 53 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн байна.



## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Мэдээллийн ил тод нээлттэй байдлын 46 үзүүлэлтээс аймгаас гарах боломжгүй буюу хэрэгжилт тооцох хугацаа болоогүй 2 үзүүлэлт байна. Нийт 44 үзүүлэлтийн дундаж хувь 100 хувьтайгаар үнэлж, үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2022 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж өгсөн зөвлөмжийн дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарыг заавал ажиллуулж, байгууллагын цахим хуудсыг нээлттэй мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн хангах 1 зорилт 8 арга хэмжээ, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр 1 зорилтын хүрээнд 7 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлснээр мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үзүүлэлт ахисан үзүүлэлттэй байна.

“Цахим үндэстэн-E-Nation” зорилтын хүрээнд мэдээллийн технологийн чиг үүрэг бүхий албан хаагчдын мэдлэг чадварыг сайжруулах замаар иргэд, төрийн албан хаагчдын цахим ур чадвар /тоон бичиг үсэг-Digital literacy/-ийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг төлөвлөн нийт 65 удаагийн сургалтыг зохион байгуулж танхимаар 1575, цахимаар 1354 нийт 2929 иргэн, төрийн албан хаагчдад цахим ур чадварын сургалтыг зохион байгуулснаар олон нийтэд хүргэж буй мэдээллийн хүртээмжтэй байдал нэмэгдэн иргэд цаг хугацаандаа мэдээлэлээ авах боломж бүрдсэн гэж үзэж болохоор байна.









## ТАВ: ЗӨВЛӨМЖ

Аймгийн сайтад ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллээ цаг хугацаанд нь бүрэн байршуулахад бодлогын хэлтсүүд анхаарах

Сум, агентлагийн ил тод байдлын үзүүлэлтийн үнэлгээг өмнөх оноос нэмэгдүүлэх чиглэлээр арга зүйгээр хангаж ажиллах /Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ДААРИЙМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Л.МЯГМАРМЯДАГ